



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 319

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Шатрын их мастер Г.Мөнхгалын нэрэмжит “Өвөрхангай-2022” нээлттэй тэмцээнийг Арвайхээр суманд 2022 оны 06 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, тэмцээний зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Өвөрхангай-2022” тэмцээнд 19,459,000 (арван есөн сая дөрвөн зуун тавин есөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

3.Дээрх зардлын 19,459,000 (арван есөн сая дөрвөн зуун тавин есөн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

4.Тэмцээний бэлтгэл, зохион байгуулалт, аюулгүй байдлыг сайтар ханган ажиллахыг зохион байгуулах хорооны дарга (С.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

6222 11 0685

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 16-ны өдрийн
11319 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



ШАТРЫН ИХ МАСТЕР Г.МӨНХГАЛЫН НЭРЭМЖИТ “ӨВӨРХАНГАЙ-2022”
НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга: С.Ундрах (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Ө.Жандүдсансүм (аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн
тамир, спортын газрын дарга)

С.Чимэддорж-Ойдов (аймгийн Засаг даргын дэргэдэх
Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

С.Хүрэлбат (аймгийн Шатрын холбооны Удирдах зөвлөлийн
гишүүн)


Ө.Баттөр (аймгийн Шатрын холбооны нарийн бичгийн дарга)

Б.Бямбадорж (Уянга сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Баттүшиг (аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн
тамир, спортын газрын Спортын хэлтсийн дарга)

-оОо-

Аймгийн Засаг даргын 2022 оны
 06 дугаар сарын 16-ны өдрийн
 1319 дугаар захирамжийн
 02 дугаар хавсралт



ШАТРЫН ИХ МАСТЕР Г.МӨНХГАЛЫН НЭРЭМЖИТ "ӨВӨРХАНГАЙ-2022"
 НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭНИЙ ЗАРДАЛ

№	Шагналын зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шагналын сан				14,650,000
2	Медаль	ш	18	15,000	270,000
3	Өргөмжлөл	ш	35	5000	175,000
4	Анонс	м ²	18м ²	8000	144,000
5	Ерөнхий болон туслах шүүгчийн гэрээт ажлын зардал	өдөр	3	540,000	1,620,000
6	Шатар	ш	30	30,000	900,000
7	Шатрын цаг	ш	20	85,000	1,700,000
Нийт					19,459,000